ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2021 оны 12 сарын 23 өдөр Дугаар А/31 Арвайхээр

Хөрөнгийн тооллогын комисс томилох тухай

Засгийн газрын 2003 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай" 241 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тооллогыг 2022 оны 1 дүгээр сарын 10-ны дотор хөрөнгийн нэг бүрчилсэн байдлаар эд хариуцагч нарт хөрөнгө эзэмшигчийн картаар хариуцуулан баталгаажуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхөж ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг акталж, данснаас хасах, хөрөнгийн жагсаалтыг мэргэжилтнүүдийн хурлаар хэлэлцэж аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх, дүнг илтгэх хуудсаар мэдээлэх ажлуудыг зохион байгуулахыг тооллогын комиссын ахлагч (Н.Төгс-Очир), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2021.. оны 12 сарын 23 өдрийн
А/31. дугаар тушаалын хавсралт

ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч; Н.Төгс-Очир -Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: М.Мөнхбаатар -Эдийн засагч

Н.Отгонбаяр- Гамшиг, цус цусан бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтэн

Э.Лхавгадулам- Даргын туслах

Ц.Гочоомаа- Үйлчлэгч